

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:
 Булган аймаг дахь
 Төрийн аудитын газар

Тэргүүлэх Аудитор
 Д.Анхбаяр

Аудитын менежер
 Ж.Энхцоодол

Ахлах аудитор
 Г.Ганбаатар

Аудитор
 П.Мөнхтуяа

2018 оны 11 дүгээр сар

Аудитын тайлантай
 холбоотой асуудлаар
 нэмж тодруулах асууж
 лавлах зүйл байвал
 70342495 дугаарын утас,
 70342580 дугаарын
 факсаар харилцана уу.

Цахим хаяг:
 Bulgan@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт.....2

Аудитын зорилт,хамрах хүрээ, арга зүй.....3-4

БҮЛЭГ 1. Аймгийн 80 жилийн ойн хүрээнд тодорхой ажил хийгдсэн боловч ч аймгийн салбар хороо ажлаа тайлагнаагүй, иргэдэд мэдээлээгүй, салбар хороодын санхүүгийн тайлан байхгүй байна.

1.1.Аймгийн 80 жилийн ойг угтаж хийх бүтээлч 80 ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 87 хувьтай байна.....4-5

1.2. Салбар хороод ажлын тайлангаа ирүүлсэн боловч санхүүгийн тайлан, бэлэн мөнгөний тооцоо, төсвийн зарцуулалтын баримтгүй зөрчил их байна.....5-7

БҮЛЭГ 2. Аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дансны хуулгаар 2593.7 сая төгрөгийн хандив орлого төвлөрсөн боловч санхүүгийн баримтыг ирүүлээгүй.

2.1 Ойн арга хэмжээний эх үүсвэрийг хууль зөрчин төлөвлөж “Булган инноваци клуб” ТТБ-ын дансаар дамжуулан орлого бүрдүүлжээ.....7

2.2. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс ойн арга хэмжээнд хөрөнгө зарцуулах шаардлагагүй байхад 260.9 сая төгрөгийг зарцуулсан байна.7-8

2.3. Аймгийн 80 жилийн ойн хандивын зарцуулалтын 2231378.7 мянган төгрөгийн санхүүгийн тайлан тооцоог гаргаагүй байна.....8-9

2.4. Хандивын бүрдүүлэлт, зарцуулалтыг 8 суманд шалгахад хандивт ирсэн мал, материал, бэлэн мөнгийг зарим суманд шууд зарцуулсан, үр дүн багатай, дотоод хяналт сул ажилласан байна.....9-10

БҮЛЭГ 3. Байгаль хамгаалах сангаас 55.1 сая төгрөгний ажил үйлчилгээг тендер сонгон шалгаруулалт зарлаагүй, ТБОНӨХБАУХАТ хуулийг зөрчиж шууд гэрээ байгуулсан.

3.1 УТХО болон ОНТХО, сангуудын хөрөнгийг хуулийн дагуу зарцуулаагүй, зарим ажлуудыг сонгон шалгаруулалтгүй явуулсан байна.....10-13

ДҮГНЭЛТ :.....13-14

ЗӨВЛӨМЖ:.....14

Хавсралтууд

Тайлан баталгаажуулсан тушаал

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний Аудитын газар
ТХШТХ	Төрийн хяналт шалгалтын тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТТХ	Төсвийн тухай хууль
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртөгийн албан татвар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

2018.10.28.

Булган

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан Үндэсний аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ, аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт:

Аудитын зорилт нь аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн хэрэгжилтийн үр дүн, 80 жилийн ойн санхүүгийн эх үүсвэр хандивын бүрдүүлэлт, зарцуулалт, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгийн зарцуулалт, ойн арга хэмжээний хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтанд тавих дотоодын хяналтыг хэрхэн үр ашигтайгаар хэрэгжүүлж ямар үр нөлөөтэй ажилласанд дүгнэлт өгч шаардлагатай бол санал боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэхэд оршино.

- Аймгийн 80 жилийн бүтээлч ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын тайлан
- 80 жилийн ойн арга хэмжээний орлого, хандивын бүрдүүлэлт, үр дүн,
- Хөрөнгө оруулалт, бүтээн байгууллалтын зарцуулалт,
- Хандив зээл тусламжийн зарцуулалт, үр дүн,
- Баяр наадмын үйл ажиллагааны зарцуулалт,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн,
- Байгууллага, иргэд, орон нутгийн оролцоо ажлын үр дүн,
- Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдал,
- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт,

3. Аудитын хамрах хүрээ:

Булган аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээний ажлын хэрэгжилт, хандив зээл тусламжийн бүрдүүлэлт, зарцуулалт, бүтээн байгууллалт төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, аймгийн ЗДТГ, Х өрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, ГХБХБГ, Булган сумын ЗДТГ болон ажлын хэсгүүдийн ажлын гүйцэтгэл санхүүгийн тайлан тооцоо, хяналт үр дүнг хамруулаа.

4. Шалгуур үзүүлэлт

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм журам
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол
- Засаг даргын захирамжийн хэрэгжилт
- Гэрээний биелэлтийг тооцох
- Холбогдох бусад хууль, тогтоомж

5. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Аймаг дахь Төрийн аудитын газрын даргын баталсан удирдамжаар аймгийн тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, менежер Ж.Энхцоодол хяналт тавьж, ахлах аудитор Г.Ганбаатар, аудитор П.Мөнхтуяа нар 2018 оны 09 дугаар сарын 10-наас эхлэн ажлын 40 хоногт багтаан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Ерөнхий мэдээлэл:

Булган аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 107 тоот тогтоолын 1 дэх заалтаар “Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд бэлтгэх аймгийн комисс”-ыг 52 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж комиссын даргаар аймгийн Засаг дарга, орлогч даргаар Засаг даргын орлогч, нарийн бичгийн даргаар ТГ-ын дарга, ИТХТ-чдийн нарийн бичгийн дарга нар, 2 дахь заалтаар аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг угтаж хийх ажлын 5 салбар комиссуудыг байгуулжээ.

Аймгийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/407 тоот захирамжын 1 дүгээр хавсралтаар аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах аймгийн хороог 27 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж хорооны даргаар аймгийн Засаг даргын орлогч, 2 дугаар хавсралтаар 80 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах 10 салбар хороог байгуулж, 80 жилийн ойн баяр наадмын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гаргах, ойн баяр наадмын хүрээнд хийгдэх арга хэмжээний жагсаалт, төсөв санхүүгийн тооцоо гаргах, салбар комиссуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх удирдлагаар хангахыг даалгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 167 дугаар тогтоол Булган аймгийн баяр наадмыг 2018 оны 07 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд тэмдэглэх тухай шийдвэр гарчээ.

Булган аймаг дахь Төрийн Аудитын газар

Аймгийн 80 жилийн ойн аймгийн хороо, салбар хороодын ажлын үр дүн

Бүлэг 1

Аймгийн 80 жилийн ойн хүрээнд тодорхой ажил хийгдсэн боловч ч аймгийн салбар хороо ажлаа тайлагнаагүй, иргэдэд мэдээлээгүй, салбар хороодын санхүүгийн тайлан байхгүй байна.

1.1. Аймгийн 80 жилийн ойг угтаж хийх бүтээлч 80 ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 87 хувьтай байна.

Булган аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн баяр наадам өргөн дэлгэр, өндөр зохион байгуулалттай, наадмын нээлт наадмын талбайн өнгө төрх, хүн бүрийн

сэтгэлд хүртэл аймгийн 80 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах аймгийн хороо, салбар хороодын бүх гишүүд, иргэд сайн ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолоор аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг угтаж хийх бүтээлч 80 ажлын жагсаалт, аймгийн 80 жилийн ойд бэлтгэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсан

Булган аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах аймгийн комиссын ажлын тайлан ирүүлээгүй, аймгийн 80 жилийн ойг угтаж хийх бүтээлч 80 ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 87 хувьтай 5 ажил огт хийгдээгүй, 1 ажил 20, 1 ажил 30, 3 ажил 40 хувьтай биелэлтийг тооцсон байна.

Аймгийн бүтээлч 80 ажлаас Бунхан толгой дахь алдартнуудын хөшөө цогцолборыг дуусгах, Хатанбаатар Магсаржавын цогцолборыг барих, Хүүхдийн жаргалант зусланг барьж ашиглалтанд оруулах, Дашчойнхорлин хийд Цагаан суваргатай холбох авто зам барих, Булган суманд дугуйн жишиг зам тавих зэрэг 5 ажил хөрөнгийн эх үүсвэргүй хийгдээгүй, Аймгийн төвийн цэвэрлэх байгууламж барих ажлыг 20 хувьтай гэж дүгнэсэн ажил эхлээгүй, Мал, мах, түүхий эд худалдан борлуулах захыг бий болгох ажил 30 хувьтай гэж дүгнэсэн үйлдвэржилтийн бүсэд “Цонхот” ХХК, иргэн Дагий нарт тус бүр 0,5 га газар олгосон тодорхой ажил хийгээгүй,

Мөн аймгийн төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэх, өргөтгөх, ажил 2019 оноос эхлэх хөрөнгийн эх үүсвэргүй, Нийтийн биеийн тамирын талбай бий болгох ажил хийгдээгүй, Цана, тэшүүрийн баазтай болох ажлыг “Эвсэг сайхан” ХХК өөрийн хөрөнгөөр хийх зэрэг 3 ажлууд хийгдээгүй 40 хувьтай гэж дүгнэгдсэн байна.

1.2. Салбар хороод ажлын тайлангаа ирүүлсэн боловч санхүүгийн тайлан, бэлэн мөнгөний тооцоо, төсвийн зарцуулалтын баримтгүй зөрчил их байна.

1.2.1. Нийгэм соёл, спортын салбар хороо.

Аймгийн 80 жил угтаж нийгэм соёлын чиглэлийн 13 ажил төлөвлөсөн нийгэм соёлын хүрээнд зохион байгуулсан ажлууд үр дүнтэй хэрэгжсэн боловч зарим ажлын гүйцэтгэл тодорхойгүй биелэлтийг тооцоогүй тухайлбал: Аймгийн түүхт 80 жилийн баримтат кино зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажлын зардал тодорхойгүй, шилдэг лого шалгаруулсан, энгэрийн тэмдэг 10000, хүндэт тэмдэг 5000 ширхэг хэвлүүлэхээр 90.0, өрхийн тоогоор гарын бэлэг 20000 ширхэг нэг бүрийн үнэ 11000 төгрөг 220.0, түүхийн ном бүтээх 2 боть 1000 ширхэг байхаар төлөвлөж 40.0, дууны цомог хэвлүүлэх 14.5, Булган нутаг-бидний бахархал уран зураг, уран баримал шалгаруулах 5.0, Музейн үзмэрийг шинэчлэх төсөл үзмэр дэлгэлт 32.6, барилга засварт 72.8, Уртын дуу морин хуур 26.2, А.Амар сайдын тухай “Монгол улс мандаг” бүрэн хэмжээний уран сайхны кино 60.0, нийт 595.5 сая төгрөг төлөвлөсөн байна.

Дээрх үйл ажиллагаанд зарцуулсан зардлын баримт байхгүй, хэдэн төгрөг зарцуулсан нь тодорхойгүй, нийгэм соёл, спортын салбар хорооны зардлын гүйцэтгэл байхгүй байна.

1.2.2. Тохижилт, үйлчилгээ хариуцсан салбар хороо:

Тохижилт, үйлчилгээний салбар хороо нь 14 хүний бүрэлдэхүүнтэй, аймгийн 80 жил ойг угтаж 2 бүлэг 34 заалттай ажлын төлөвлөгөө боловсруулж хийх ажлын зардлыг тооцон 303500.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар 29 арга хэмжээ бүрэн, 4 арга хэмжээ 90 хувьтай, 1 арга

хэмжээ хэрэгжих боломжгүй буюу төлөвлөгөө 95.8 хувийн хэрэгжилттэй төсвийн зарцуулалтын тайлан байхгүй байна.

1.2.3.Эдийн засаг, аж ахуйн арга хэмжээ хариуцсан салбар хороо.

Эдийн засаг, аж ахуйн хариуцсан салбар хороо нь аймгийн 80 жил угтаж хийх ажлын төлөвлөгөө байхгүй, хийсэн ажил нь тодорхойгүй, ажлыг дүгнээгүй байна.

1.2.4.Үндэсний бөхийн салбар хороо:

Баяр наадмын үндэсний бөхийн салбар хороо нь ажлын төлөвлөгөөг хийж батлуулан аймгийн баяр наадмын цол олгох барилдааны төсөвт 35.0, аймгийн 80 жилийн хүчит бөхийн барилдааны төсөв 28.8, өсвөрийн 64 бөхийн барилдаанд 36.0, цолны хишиг 10.0, жаяг дэгийн багийн гишүүнийн зардалд 4.4, аж ахуйн зардалд 1.7, хөрөнгийн зардал 12.4 сая төгрөг буюу нийт 64.4 сая төгрөгөөр төсвийн зардлыг төлөвлөсөн хөрөнгийг орлогод аваагүй, бэлэн мөнгөний тооцоо, зарцуулалтын тайлан байхгүй зөрчил илэрсэн.

1.2.5.Хурдан морины салбар хороо:

Аймгийн баяр наадмын хурдан морины салбар хорооны ажлын төлөвлөгөө тайлан байхгүй, хурдан морины бай шагналд /хандиваас/ 254.9, бэлтгэл ажлын зардалд /төсвөөс/ 51.9, үзэгчдийн суудал авах /төсвөөс/ 18.0, телевизийн бичлэг /хандив/ 5.0, цахилгааны шугам татах /хандив/ 58.0 нийт 387.8 сая төгрөгөөр төлөвлөсөн хийсэн ажлын тайлан, мөнгөн хөрөнгийн болон эд хөрөнгийн санхүүгийн баримт, тайлан байхгүй.

1.2.6.Үндэсний сурын салбар хороо:

Баяр наадмын үндэсний сур харвааны салбар хорооны даргаар ШШГА-ны дарга д/х Д.Төгсбаяраар ахлуулсан 12 хүн ажиллаж 14 заалттай ажлын төлөвлөгөө боловсруулан наадмын зардлын төсвийг бай шагналд 37.2, бэлтгэл ажлын зардалд 25.2 сая төгрөгөөр төлөвлөж ажлын гүйцэтгэлээр 5 ханатай 1 гэр 2.5, асар авах 1.5, бай шагналд 34.8 /бай 31.5, өргөмжлөл 1.9, ашиг 1.4/, бэлтгэл ажлын зардалд 10.7, сүүдрэвч 10.5 сая төгрөг буюу нийт 60.0 сая төгрөгийг зарцуулж 2.4 сая төгрөгийг юунд зарцуулсан нь тодорхойгүй, санхүүгээс бэлэн мөнгө өгч авсан баримт байхгүй, эд хөрөнгийн тайлан байхгүй зөрчил илэрсэн.

1.2.7.Шагайн харвааны салбар хороо:

Шагайн харвааны салбар хороо нь ойн баяр наадмын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг хийж батлуулсан бай шагналд 23.0, аж ахуйн зардалд 1.8, шинэ бэлтгэл ажилд 4.1, анх нийт 28.9 сая төгрөгөөр төлөвлөж 3 удаа шинэчлэн 24.9 сая төгрөгөөр батлуулан бай шагналд 20.7 /бай 17538.4, өргөмжлөл 2341.6, ашиг 820.0/, асар 1.5, аж ахуй зардалд 2.7 сая төгрөг зарцуулсан боловч аж ахуйн материалын тайлан байхгүй, шагналаас 215.0 мянган төгрөгний ашгийн татвар дутуу суутгасан зөрчил илэрсэн.

1.2.8.Нийгмийн хэв журам сахиулах салбар хороо:

Нийгмийн хэв журам сахиулах салбар хороо аймгийн 80 жилийн ойн арга хэмжээний үеэр хэв журам тогтоох, урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө 18 заалттай боловсруулсан, 56.8 сая төгрөг төлөвлөсөн байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл тодорхойгүй, мөнгөн хөрөнгийн болон эд хөрөнгийн тооцоо, баримт тайлан байхгүй байна.

1.2.9.Хүнсний бүтээгдэхүүн, эрүүл ахуй, орчны ариун цэврийн шаардлага хангах салбар хороо:

Уг салбар хороо баяр наадмын бэлтгэл хангах 28 заалт бүхий ажлын төлөвлөгөөг хийж батлуулан 20 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж баяр наадмын үеэр түр ажлын байраар 36 хүн нэмж ажиллуулан нийт 56 хүнтэй ажилласан, төсвийг 2.5 сая төгрөгөөр төлөвлөсөн зарцуулалтын тайлан байхгүй байна.

1.2.10.Гадаадын зочин төлөөлөгч хүлээн авч үйлчлэх салбар хороо:

Гадаадын зочин төлөөлөгч хүлээн авч үйлчлэх салбар хороо нь наадмын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө, хүлээн авах хөтөлбөр зардлын төсвийг 20.0 сая төгрөгөөр хийж батлуулсан байна.

Аймгийн 80 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах салбар хороод баяр наадмын бэлтгэл хангах ажлыг төлөвлөгөөний дагуу сайн зохион байгуулсан боловч Нийгэм соёл, спортын болон эдийн засаг, аж ахуйн арга хэмжээ хариуцсан 2 салбар хороо хийсэн ажлын тайлангаа ирүүлээгүй, мөн салбар хороод баяр наадмын үйл ажиллагааны санхүү, мөнгөн хөрөнгө болон аж ахуйн тооцооны тайланг 80 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах аймгийн хороонд одоо болтол ирүүлээгүй зөрчил илэрсэн.

Баяр наадмыг зохион байгуулах салбар хороодын бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт хангалтгүй, бүртгэлгүй, эзэмшил нь тодорхойгүй зөрчил илэрсэн тул 18340.0 мянган төгрөгний хөрөнгийг байгууллагын тайлан бүртгэлд тусгуулахаар албан шаардлага бичлээ.

Булган аймаг дахь Төрийн Аудитын газар

Ойн арга хэмжээний хандивын орлогыг бодиттой төлөвлөсөн эсэх

Бүлэг 2

Аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дансны хуулгаар 2593.7 сая төгрөгийн хандив орлого төвлөрсөн боловч санхүүгийн баримтыг ирүүлээгүй.

2.1. Ойн арга хэмжээний эх үүсвэрийг хууль зөрчин төлөвлөж “Булган инноваци клуб” ТТБ-ын дансаар дамжуулан орлого бүрдүүлжээ.

Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн баяр наадмын нийт төсвийг 1997737.8 мянган төгрөгөөр 11 арга хэмжээнд зарцуулахаар төсөвлөснөөс аймгийн Засаг дарга 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 02/1129 тоот абан бичгээр сумдын Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч 16 сум, 1 тосгоноос 80 жилийн ойн хандивт нийт 1255750.0 мянган төгрөгийн хандивын орлого бүрдүүлэх төлөвлөгөө боловсруулан баталж сум бүрт үүрэг чиглэл өгч ажилласны дагуу сумдын ирүүлсэн гүйцэтгэлээр 1044953.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн гэж тоон мэдээлэл гарч байгаа боловч сумдаас авах хандивын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн тоон мэдээллийг үзэхэд сумдаас бүрдүүлэх орлогыг 210796.6 мянган төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Аймгийн 80 жилийн ойн арга хэмжээг угтан хандивын орлогын эх үүсвэр, бүрдүүлэх орлогын дансыг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Хас банкинд 5002129178 тоот данс нээн ажилласан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдөж ажиллаагүй зөрчил илэрсэн.

АТГ-аас 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/3753 тоот албан бичиг хүргүүлсний дагуу “Булган инноваци клуб” ТТБ-тай 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр гэрээ байгуулан Хаан банкны 5431065199 тоот дансанд хандивын орлогыг бүрдүүлэх шийдвэр гарснаар хандивын орлого 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар дансанд 2114017.3, бэлнээр 85000.0, Хас банкны 5002129178 тоот

дансанд 394664.2 мянган төгрөг буюу нийт дансны хуулгаар 2593681.5 мянган төгрөгийн хандивын орлого бүрдүүлжээ.

2.2. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс ойн арга хэмжээнд хөрөнгө зарцуулах шаардлагагүй байхад 260.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 06/06 тоот тогтоолоор аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг 873.7 сая төгрөгөөр баталж 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг төлөвлөж өгөөгүй байна.

Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн үдшийн цэнгүүнд “Уран тогоо бүтээлийн нэгдэл”-д аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/394 тоот захирамжаар нийт 245.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр Засаг даргын нөөц хөрөнгөөс “Уран тогоо бүтээлийн нэгдэл”-ийн 5111457466 тоот дансанд 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдөр 100.0, 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдөр 100.0 сая төгрөгийг тус тус шилжүүлж, бусад арга хэмжээнд 72035.0 мянган төгрөг баталж гүйцэтгэлээр 60922.0 мянган төгрөгийг бэлэг дурсгал, буудал, шатахууны зардалд тус тус зарцуулсаныг түүвэрлэн шалгахад “Уран тогоо бүтээлийн нэгдэл”-ээс 200.0 сая төгрөгийн зардлын зарцуулалт, гүйцэтгэлийн тайлан мэдээг гаргуулж аваагүй, анхан шатны баримт дутуу, буудал болон бэлэг дурсгалын 14000.0, бэлгийн багцын 3000.0, буудлын зардлын 11535.0 мянган төгрөг буюу нийт 28535.0 мянган төгрөгийн тараалтын баримтгүй, орлого, зарлагын тайлангаар тайлагнаагүй зөрчлүүд илэрсэнд нийт 228535.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичлээ.

Аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулах орлогыг 2.0 тэрбум төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2.5 тэрбум төгрөгийн орлого орсон байхад аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 260.9 сая төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 239 дүгээр журмын дагуу зарцуулаагүй, ИТХ-аар батлуулаагүй зөрчлүүд илэрч байна.

Аймгийн ИТХ-аар 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 06/06 тоот тогтоолоор аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг 873.7 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 825.6 сая төгрөгийг зарцуулж 2018 оны 09 дүгээр сарын байдлаар 48.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Сангийн сайдын 239 дүгээр журмын 2.3 “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохиролыг арилгахтай холбоотой араг хэмжээг санхүүжүүлэхэд зориулж батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 80 жилийн ойн арга хэмжээнд 260.9 сая төгрөгийг зарцуулсан нь гэнэтийн гамшигт зарцуулах нөөц хөрөнгөнд байлгах хөрөнгийн хэмжээг тооцоогүй, эрсдэл дагуулах магадлалтай байна.

2.3. Аймгийн 80 жилийн ойн хандивын зарцуулалтын 2231.4 сая төгрөгийн санхүүгийн тайлан тооцоог гаргаагүй байна.

Булган аймгийн 80 жилийн ойн хандивыг дансны хуулгаар тооцоход 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн “Булган инновци клуб” ТТБ-ын 5431065199 тоот дансны хуулгаар 2414017.3 мянган төгрөг төвлөрсөнөөс 2222769.4 мянган төгрөгийг зарцуулж 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 191247.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, Хас банкны 5002129178 тоот данснаас 8609.3 мянган төгрөгийг зарцуулж 86354.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн Хас банкны 5002129178 тоот дансыг 2018 оны 04 сарын 30-ны АТГ-ын 01/3753 тоот “Зөвлөмж хүргүүлэх тухай” албан тоотын дагуу ажиллаагүй уг дансыг одоо болтол хаагаагүй 86354.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй зөрчил илдэрсэнд

“Булган инноваци клуб” ТББ-ын 5431065199 тоот дансанд дээрхи дансны үлдэгдлийг төвлөрүүлэх төлбөрийн акт бичлээ.

Дансны хуулгаар гарсан нийт 2231378.7 мянган төгрөгийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, анхан шатны баримтыг удаа дараа шаардсан боловч аймгийн ЗДТГ нь “Булган инноваци клуб” ТББ-тай байгуулсан гэрээ, ХААН банк, ХАС банкны дансны хуулгыг өгч бусад холбогдох санхүүгийн баримтыг ирүүлээгүй байна.

Хамтын ажиллагааны гэрээ байгуулах тухай 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 тоот гэрээнд хандивын орлого бүрдүүлэх, тайлагнах тухай “Булган инноваци клуб ТББ”-тай гэрээ байгуулж гэрээнд тайлагнах хугацаа бичигдээгүй, тодорхой бус, гэрээнд талууд сар бүрийн 4 дэх 7 долоо хоногт дүгнэнэ гэж заасны дагуу гэрээг дүгнэж ажиллаагүй зөрчлүүд илэрлээ.

“Булган инноваци клуб” ТББ-ын дансаар хандивын орлогыг дамжуулан бэлнээр болон бэлэн бусаар зарцуулсан, тус ТББ нь юунд мөнгийг зарцуулахаа мэдэхгүй, аймгийн СТСХ-ийн дарга, баяр наадам зохион байгуулах хороо, салбар хороод бэлнээр мөнгийг авч зарцуулсан, мөн аймгийн ЗДТГ-ын удирдлагуудаас амаар өгсөн зааврын дагуу тус ТББ мөнгөн шилжүүлэг хийж зарцуулсан нь төрийн албан хаагч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулж, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн зөрчил илэрч байна.

“Булган инноваци клуб” ТББ-ын дансаар хандивын орлогыг дамжуулан хяналтгүй, сонгон шалгаруулалтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25.6 “Тусламжийн орлогоос санхүүжүүлэхэд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэгэн адил баримтлана”, 25.7 “Тусламж хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана”, 25.8 “Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл сум дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллахаас зайлс хийсэн нь тодорхой байна.

Мөн аймгийн түүхт 80 жилийн ойн арга хэмжээний гүйцэтгэлд аудит хийх хугацаа 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд аймгийн Засаг даргад албан тоот хүргүүлэн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэнгүүдтэй биечлэн уулзаж 80 жилийн ойн арга хэмжээний хандивын орлого, хөрөнгийн зарцуулалтын тайлан, анхан шатны баримтыг удаа дараа шаардсан боловч санхүүгийн баримтыг өгөөгүй, 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр “Булган инноваци клуб” ТББ-ын ХААН банкны дансны хуулгыг, 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдөр ХАС банкны дансны хуулгыг тус тус өгсөн, хандивын орлого зарлагын дүнг нэгтгэн тайлагнасан хандивын санхүүгийн баримт, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын тайланг ирүүлээгүй болно.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 28.1.”Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд

хүргүүлнэ.” гэж заасны дагуу холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.

2.4. Хандивын бүрдүүлэлт, зарцуулалтыг 8 суманд шалгахад хандивт ирсэн мал, материал, бэлэн мөнгийг зарим суманд шууд зарцуулсан, үр дүн багатай, дотоод хяналт сул ажилласан байна.

Булган аймгийн хэмжээнд 80 жилийн ойн арга хэмжээнд зориулан 16 сум нэг тосгоноос урьдчилсан байдлаар нийт 1044953.4 мянган төгрөгийн хандив цугларсан мэдээлэл байгаа боловч Хишиг-Өндөр, Могод, Гурванбулаг, Баяннуур сумдын хандив, зарцуулалтыг түүвэрлэн шалгахад аймгийн 80 жилийн ойн хандивын ажлын хэсэг томилон ажилласан боловч дотоод хяналт тавьж ажилласан ажлын хэсгийн тайлан тооцоо гаргаагүй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, зориулалт бус зарцуулсан, өглөг, авлага үүсгэсэн, сумын иргэд, олон нийтэд хандивын орлого, зардлын зарцуулалтын тайлан мэдээг тайлагнаагүй зэрэг зөрчлүүд илэрч байна.

Тухайлбал: Хишиг-Өндөр сум нь хандивын орлогоос 100.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн, 4.7 сая төгрөгийг зарцуулсан гэх боловч нярав амарсан шалтгаанаар анхан шатны баримтыг шалгуулаагүй, Гурванбулаг сум нь хандивын орлогын 209.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан, жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, Могод сум нь 175.0 мянган төгрөгийн ХХОАТ суутган тооцоогүй зэрэг зөрчилд нийт 484.0 мянган төгрөгийн төлбөрийн актаас аудитын явцад 309.0 мянган төгрөгийг барагдуулж 175.0 мянган төгрөгт төлбөрийн акт, 3017.3 мянган төгрөгт албан шаардлага тус тус бичлээ.

Дээрхи зөрчлүүд нь сумдад томилогдсон ажлын хэсгийн гишүүд дотоодын хяналтыг тавьж ажиллаагүй, үр дүн багатай, НББ-ийн тухай хуулийн 13.6.”Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13.7.”Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, ХХОАТ-ын тухай хуулийн 23.1”энэ хуулийн 17-19 дүгээр зүйл 20.1.2-201.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Цаашид ажлын хэсгийн салбар комис ажлаа сайжруулан, ажиллаж цаг хугацаандаа ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг олон нийт иргэдэд мэдээлэн хууль журмын дагуу үр дүнтэй төсвийг зарцуулж байх шаардлагатай байна.

Булган аймаг дахь Төрийн Аудитын газар

Аймгийн 80 жилийн ойн хүрээнд хийгдсэн УТХО болон ОНТХО, сангуудын төлөвлөлт, зарцуулалтын үр дүн

Бүлэг 3

Байгаль хамгаалах сангаас 55.1 сая төгрөгний ажил үйлчилгээг тендер сонгон шалгаруулалт зарлаагүй, ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчиж шууд гэрээ байгуулсан.

3.1. УТХО болон ОНТХО, сангуудын хөрөнгийг хуулийн дагуу зарцуулаагүй, зарим ажлуудыг сонгон шалгаруулалтгүй явуулсан байна.

Аймгийн 80 жилийн ойг угтаж хийх ажлын хүрээнд УТХО-аас 995.5, ОНТХО-аас 1386.4, ОНХС-гаас 30.4, аймгийн авто замын сангаас 2017 онд 306.9, 2018 онд 251.3, БХС-гаас 774.6 нийт 3745.1 сая төгрөгний хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын арга хэмжээний ажлуудыг хийсэн байна.

Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, сангуудын хөрөнгийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад ажил гүйцэтгэх гэрээнд техник хяналтын зардлыг тусгаагүй, хугацаа хэтэрсэн, гэрээнд заасны дагуу санхүүжилтийн хуваарийг олгоогүй, шууд гэрээ байгуулсан, зураг төсвийн үнийг төлөвлөөгүй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу гүйлгээ хийгдсэн, зориулалт бус зарцуулсан, сонгон шалгаруулалтгүй хууль зөрчиж гэрээ байгуулсан зэрэг зөрчлүүд илэрч байна.

Тухайлбал: ОНХС-гаас санхүүжсэн Булган аймгийн Музейн үзмэр дэглэлтийг шинэчлэх ажлыг 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/284 тоот захирамжаар 30797.2 мянган төгрөгийг баталж гүйцэтгэгчээр Монголын үндэсний Музейн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Наранчимэгтэй гэрээг 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл байгуулж ажлыг 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 01 дугаартай акт үйлдэн хүлээлгэн өгсөн нь гэрээний хугацаанд ажлыг гүйцэтгээгүй 35 хоногоор хугацаа хэтэрсэн, гэрээнд заасны дагуу алданги тооцоогүй, Төрийн сан нь санхүүжилтийг олгохдоо анхан шатны баримтын бүрдэлт дутуу гүйлгээ хийжээ.

Мөн 2017 оны авто замын сангаар санхүүжсэн Орон нутгийн авто зам, замын байгууламжийн шинэчлэл /зураг төсөв хийгдсэн, ЭӨЦС, Хүний хөгжлийн төв, ЭМГ, Монос, Бага сургууль, 20 гаруй уулзвар/-ын, Булган сум 1-р сургуулийн зогсоолын, Булган сумын халуун ус, МСҮТ замын урд тал, ГХБХБГ, Жаран цайны газрын зогсоолын, Булган сумын 4-р цэцэрлэг, 9-р байрны зүүн талын зогсоолын, Булган сум ЭЗО ХХК, Музей, Монос эмийн сан, Од дэлгүүрийн зогсоолын ажлуудын гэрээнд техник хяналтын зардлыг тусгаагүйгээр гэрээ байгуулсан, аймгийн Соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтийн ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу шат дараатайгаар хийж гүйцэтгэх ажлын, Аялал жуулчлалын цогцолбор байгуулах ажлын, Чинван Ханддоржын талбайн тохижилтийн, гэрэлтүүлэгийн ажлуудын хугацаа хэтэрсэн, Ахмадын амралтын замын засвар /Булган сум/ ажлын хугацаа хэтэрсэн, санхүүжилтийг хуваарийн дагуу олгоогүй, Аялал жуулчлалын цогцолбор байгуулах /Булган сум/ ажил, Спорт ордны засвар ажлууд нь ажил хүлээлцсэн актгүй, Байгаль орчны бодлого, статистик мэдээллийн ном хэвлүүлэхэд 15.0, аймгийн байгаль, түүх, соёлын аялал жуулчлалыг сурталчлах /альбом гаргах, зургийн цомог/ ажлыг 70.0 сая төгрөгөөр баталж “Би саунд продакшн” ХХК-д 27.9, “Эдмаркет” ХХК – д 27.2 сая төгрөгийн гүйцэтгэлээр ажлыг хийлгэсэн нь тендер зарлаагүй, шууд гэрээ байгуулсан, зориулалт бус зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрч байна.

Дээрхи зөрчлүүд нь ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийн 12.2 дугаар заалтууд, Бараа ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний 40.2 дахь заалтын 40.3.4 “захиалагчийн хяналт болон бусад нөхцөл”, НББ –ийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.2 “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 30.4.3.энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”, Төсвийн тухай хуулийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгууллагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 2017 оны жагсаалтанд аймгийн 80 жилийн ойтой холбоотой 3 төсөл арга хэмжээ батлагдсан боловч Наадмын талбайг шинэчлэх 252845.0, Төвийн гэрлийн шинэчлэл 477101.0 мянган төгрөгний 2 ажил хийгдээгүй он

дамнасан, харин Булган сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдсэн тендерт “Сэлэнгэ есөн эрдэнэ” ХХК шалгарч 491229.8 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай 2017 оны 08 дугаар сарын 14-ний өдөр гэрээ байгуулж төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, ус зайлуулах хоолой, явган хүний зам, Булган сумын ЗДТГ-ын өмнөх “Дэвшилт” ХХК-ний өмнөх, “Мээж”-ийн урд, зүүн талын зогсоолуудын ажлуудыг хийж гүйцэтгэн 439216.4 мянган төгрөг зарцуулж төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажил 95.4 хувийн гүйцэтгэлтэй он дамнасан ажил гэрээний дагуу хийгдсэн байна.

Аймгийн 80 жилтэй холбоотой 2018 оны орон нутгийн хөрөнгө оруулалтанд 9 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 1378259.6 мянган төгрөг батлагдан зарцуулсан байна. Үүнд:

1. Аймгийн баяр наадмын талбайг шинэчлэн засварлах төсөл, арга хэмжээ 252845.0 мянган төгрөгний төсөвт өртөгтэй. Зураг төсвийг “ББСМО” ХХК хандиваар 60.0 сая төгрөгөөр хийж өгсөн байна.

Сонгон шалгаруулалтанд “Мөнх аригу трейд” ХХК шалгарч 205432.6 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай 2018 оны 01 дугаар сарын 18-ны өдөр гэрээ байгуулж гадна төмөр цагаан хашаа, явган хүний зам зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Уг компанид давуу эрх олгож нэмэлт санхүүжилтээр наадмын талбайд сурын талбай байгуулах орчныг тохижуулах ажлыг 30500.0 мянган төгрөгөөр хийлгэхээр аймгийн Засаг дарга шууд гэрээ байгуулж 26973.4 мянган төгрөгний ажлын гүйцэтгэл гаргасан, ажил хүлээлцээгүй байна.

2. Булган сумын төвийн гэрэлтүүлгийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 477101.0 мянган төгрөгний төсөвт өртөгтэй. Зураг төсвийг 2017 онд 11.0 сая төгрөгөөр “Дукат” ХХК-иар хийлгэсэн, тендерт 2 компани шалгарсан.

-Ажил гүйцэтгэх сонгон шалгаруулалтанд “ОРКОНТЕХ” ХХК шалгарч 165933.2 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай 2017 оны 11 дугаар сарын 27-ны өдөр гэрээ байгуулж 2018 онд гэрээг сунгаж хийж гүйцэтгэжээ.

Дээрхи компаниар нэгдсэн эмнэлгээс НИК шатахуун түгээх станц хүртэл хуучин шонгийн гэрэлтүүлгийг солих ажлыг аймгийн Засаг дарга 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдөр шууд гэрээ байгуулж 19.4 төгрөгөөр хийлгэсэн.

Гэрэлтүүлгийн ажлын тендерийн сонгон шалгаруулалтанд “Виртуалсофт” ХХК шалгарч 224164.7 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай 2017 оны 11 дугаар сарын 27-ны өдөр гэрээ байгуулж 2018 онд гэрээг сунгаж хийж гүйцэтгэсэн.

Мөн дээрхи компаниар аймгийн ЗДТГ-аас хуучин 2-р цэцэрлэг хүртэл явган хүний замын гэрэлтүүлэгийн ажил хийхээр аймгийн Засаг дарга 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдөр 33800.0 мянган төгрөгөөр шууд гэрээ байгуулсан.

3. Булган сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлын 52013.6 мянган төгрөгний санхүүжилтийг ажил хүлээлцэх комиссын дүнгэлтийг үндэслэн олгосон.

4. Булган сумын орон сууц байрны орчин нөхцөл, өнгө үзэмжийг сайжруулах 4 төсөл, арга хэмжээ 240.0 сая төгрөгний төсөвт өртөгтэй. Орон сууцны 8 байрыг засварлахаар 4 компанитай аймгийн Засаг дарга гэрээ байгуулж 216167.2 мянган төгрөгөөр хийлгэсэн. Зураг төсвийг 2018 онд 6.4 сая төгрөгөөр “Үндсэн төсөл” ХХК-иар хийлгэсэн.

Аймгийн Засаг дарга “Цонхот” ХХК-тай 2018 оны 05 дугаар сарын 17-ний өдөр 22 дугаар байрнаас “Булган буудал” хүртэл явган хүний замын ажлыг 8.8 сая төгрөгөөр хийлгэх гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлжээ.

5. “Сансар” 1, 2 цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил 34.0 сая төгрөгний төсөвтэй ажлыг аймгийн Засаг дарга 2018 оны 04 дугаар сарын 23-ны өдөр “ЭЙ ЭНД ЖИ МОНОЛЛИТ” ХХК-тай гэрээ байгуулж ажлыг 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдөр комисс хүлээн авсан.

6. Булган сумын 3 дугаар багийн А-Б хэсгийн хоорондох 0,55 км хатуу хучилттай авто замын ажил 322.0 сая төгрөгний төсөвт өртөгтэй. Тендерийн сонгон шалгаруулалтанд “Булган АЗЗА” ХХК шалгарч 294094.2 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай 2018 оны 04 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулж хийж гүйцэтгэсэн боловч ажил хүлээлцээгүй байна.

Зүүн түрүүний авто замын засварын ажлыг 40.0 сая төгрөгөөр хийхээр аймгийн Засаг дарга 2018 оны 05 дугаар сарын 23-ний өдөр “Булган АЗЗА” ХХК гэрээ байгуулж 28205.8 мянган төгрөгний санхүүжилт олгосон, одоо болтол ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэж байна.

Байгаль хамгаалах сангаас нийтдээ 55.1 сая төгрөгний ажил үйлчилгээг тендер сонгон шалгаруулалт зарлаагүй, ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчиж шууд гэрээ байгуулсан, Төсвийн тухай хуулийн 42-ын 7 дахь заалтыг зөрчсөн, мөн Төсвийн тухай хуулийн 24.4 дэх заалт “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж аймгийн СТСХ ажил гүйлгээг санхүүжүүлсэн зөрчил илэрсэн тул холбогдох албан тушаалтнуудад арга хэмжээ авах албан тоот хүргүүлсэн.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Иргэд аж ахуйн нэгжүүдээс нийт 2.6 тэрбум төгрөгийн хандивын орлого бүрдүүлсэн байна.
- Наадмын бэлтгэл үйл ажиллагаанд ард иргэд, ААН, төрийн байгууллагын албан хаагчид бүгд идэвх зүтгэлтэй оролцсон байна.
- Хандив тусламж, төсвийн хөрөнгөөр олон бүтээн байгуулалт хийж, аймгийн төвийн өнгө үзэмжийг сайжруулж, аймагт үлдэцтэй ажил ихээр хийсэн байна.
- Сум, орон нутгийн иргэд байгууллагууд мөн өөрсдийн орон нутагт тодорхой ажил зохион байгуулж ажилласан байна.
- Наадмын ерөнхий зохион байгуулалт сайн байж наадмыг ард иргэдийн сэтгэлд нийцсэн өргөн дэлгэр хийсэн байна.
- “Булган инноваци клуб” ТББ-ын дансаар хандивын орлогыг дамжуулан бэлнээр болон бэлэн бусаар аймгийн СТСХ-ийн дарга, баяр наадам зохион байгуулах хороо, салбар хороод бэлнээр мөнгийг авч зарцуулсан, мөн аймгийн ЗДТГ-ын удирдлагуудаас амаар өгсөн зааврын дагуу тус ТББ мөнгөн шилжүүлэг хийж зарцуулсан нь төрийн албан хаагч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулж, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн зөрчил илэрч байна.

- “Булган инноваци клуб” ТББ-ын дансаар хандивын орлогыг дамжуулан хяналтгүй, сонгон шалгаруулалтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25.6 “Тусламжийн орлогоос санхүүжүүлэхэд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэгэн адил баримтлана”, 25.7 “Тусламж хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана”, 25.8 “Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл сум дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллахаас зайлс хийсэн нь тодорхой байна.
- Аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулах орлогыг 2 тэрбумаар төлөвлөж гүйцэтгэлээр 2.6 тэрбум төгрөгийн орлого орсон байхад аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 260.9 сая төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 239 дүгээр журмын дагуу зарцуулаагүй, ИТХ-аар батлуулаагүй зөрчлүүд илэрч байна.
- Аймгийн ИТХ-аар 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 06/06 тоот тогтоолоор аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг 873.7 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 825.6 сая төгрөгийг зарцуулж 2018 оны 09 дүгээр сарын байдлаар 48.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Сангийн сайдын 239 дүгээр журмын 2.3 “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохиролыг арилгахтай холбоотой арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 80 жилийн ойн арга хэмжээнд 260.9 сая төгрөгийг зарцуулсан нь гэнэтийн гамшигт зарцуулах нөөц хөрөнгөнд байлгах хөрөнгийн хэмжээг тооцоогүй, эрсдэл дагуулах магадлалтай байна.
- Дансны хуулгаар гарсан нийт 2231.4 сая төгрөгийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, анхан шатны баримтыг удаа дараа шаардсан боловч аймгийн ЗДТГ нь “Булган инноваци клуб” ТББ-тай байгуулсан гэрээ, ХААН банк, ХАС банкны дансны хуулгыг өгч бусад холбогдох санхүүгийн баримтыг ирүүлээгүй байна.
- Хамтын ажиллагааны гэрээ байгуулах тухай 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 тоот гэрээнд хандивын орлого бүрдүүлэх, тайлагнах тухай “Булган инноваци клуб ТББ”-тай гэрээ байгуулж гэрээнд тайлагнах хугацаа бичигдээгүй, тодорхой бус, гэрээнд талууд сар бүрийн 4 дэх 7 долоо хоногт дүгнэнэ гэж заасны дагуу гэрээг дүгнэж ажиллаагүй зөрчлүүд илэрч байна.
- Байгал хамгаалах сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулж ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийн 12.2 дугаар заалтуудыг мөрдөж ажиллаагүй, аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас нийтдээ 55.1 сая төгрөгний ажил үйлчилгээг тендер сонгон шалгаруулалт зарлаагүй, ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчиж шууд гэрээ байгуулсан, Төсвийн тухай хуулитын 24.4 дэх заалтыг зөрчсөн, гэрээний хугацаа хэтэрсэн, гүйцэтгэгчид алданги тооцоогүй, санхүүжилтыг олгосон байна.
- Аймгийн 80 жилийн ойн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн ИТХ-ын даргад:

- Аймгийн 80 жилийн ойн арга хэмжээний хандивын зарцуулалтын тайлан тооцоог гаргуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР
Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Г.ГАНБААТАР
П.МӨНХТУЯА

Булган аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын
20.... оны.... сарын....өдрийн ...тоот
тушаалын хавсралт

АЙМАГ БАЙГУУЛАГДСАНЫ 80 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛБӨР ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

2018.11.21

Булган

Д/д	Албан тушаал	Хариуцах эзэн	Акт, албан шаардлагын дугаар	Төлбөр зөрчлийн товч утга	Төлбөр, зөрчлийн нийт дүн	Үүнээс			
						Акт	Албан шаардлага	Барагдуулсан	
								Төлбөр	Зөрчил
1	Аймгийн Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга	Ц.Бат-Өлзий, О.Наранжаргал	БуАТАГ/2018/-ГА-02/89	Хандивын дансны үлдэгдэл төвлөрүүлээгүй.	86354572	86354572			
2	Аймгийн Засаг дарга, нягтлан бодогч	З.Батзориг, Д.Баясгалан	БуАТАГ/2018/-ГА-02/03/82	Анхан шатны баримтын бүрдэл, гүйцэтгэлийн тайлан дутуу	228535000	228535000			
3	Аймгийн Засаг даргын орлогч, ТЗУХ-ийн дарга	Ц.Бат-Өлзий, Д.Эрдэнэбилэг	БуАТАГ/2018/-ГА-02/02/59	Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын эзэмшигч тодорхойгүй,	18340000	18340000			
4	Гурванбулаг сумын ЗДТГ-ын дарга, Санхүү албаны дарга, нягтлан бодогч, нярав	Б.Эрдэнэтуяа, П.Должинсүрэн, С.Ганцоож, Ц.Эрхбат	БУААГ-2018/ГА-02/01/49	Анхан шатны баримт дутуу /80 жилийн/	3017270	3017270			
5	Санхүү албаны дарга, нягтлан бодогч	П.Должинсүрэн, С.Ганцоож	БУААГ-2018/ГА-02/	Хандивын орлогыг зориулалт бус зарцуулсан.	259000	259000	259000		

6	Могод сумын Засаг дарга, Санхүү албаны дарга	Ц.Баярсайхан, Х.Мөнх-Алтай	БУААГ-2018/ГА-02/01/26	ХХОАТ суутган тооцоогүй.	175000	175000			
7	Санхүү албаны дарга, нягтлан бодогч	Д.Энхчимэг, Болормаа	БУААГ-2018/ГА-02	Хандивын орлогыг дутуу төвлөрүүлсэн.	100000	100000		100000	
Нийт дүн					336780842	86888572	249892270	359000	0

ТӨЛБӨР ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ ГАРГАСАН:

АУДИТОР

П.МӨНХТУЯА



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2018.11.21 № 240

Танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 тушаалаар баталсан Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн "Аймаг байгуулагдсны 80 жилийн ойг угтаж 2017-2018 онд хийх бүтээлч ажлын хэрэгжилтийн үр дүн"-д сэдэвт гүйцэтгэлийн аудит хийхэд аймаг байгуулагдсны 80 жилийн ойн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас цугларсан хандивын хөрөнгийн зарцуулалттай холбоотой санхүүгийн тайлан, тооцоо холбогдох баримт материалыг аудитын явцад албан бичгээр болон харилцаа холбоогоор удаа дараа шаардсан боловч "Булган инноваци клуб" ТТБ-ын тэргүүн, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Х.Энхбат, О.Наранжаргал нар нь аймгийн 80 жилийн ойн арга хэмжээний хандив, санхүүгийн зарцуулалтын тайланг ирүүлээгүй байна.

Булган аймгийн 80 жилийн ойн хандивын хөрөнгийн орлого, зарлагыг "Булган инноваци клуб" ТББ-ын дансаар дамжуулан бэлнээр болон бэлэн бусаар зарцуулсан, тус клуб нь юунд мөнгийг зарцуулахаа мэдэхгүй, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, баяр наадам зохион байгуулах хороо, салбар хороод бэлнээр мөнгийг авч зарцуулсан, мөн аймгийн ЗДТГ-ын удирдлагуудын амаар өгсөн зааврын дагуу тус клуб шилжүүлэг хийж мөнгийг зарцуулсан нь төрийн албан хаагч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн зөрчил илэрч байна.

"Булган инноваци клуб" ТББ-ын дансаар хандивын орлогыг дамжуулан хяналтгүй, сонгон шалгаруулалтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25.6 заалт "Тусламжийн орлогоос санхүүжүүлэхэд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэгэн адил баримтлана", 25.7 "Тусламж хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана", 25.8 "Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл сум дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ" гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллахаас зайлс хийсэн нь тодорхой байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21.1 "Төрийн аудитын байгууллага, түүний ажилтнууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах аливаа мэдээллийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай авах эрхтэй. Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй", 21.2 "Төрийн аудитын байгууллагын ажилтнууд аудитын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар,

D:/Bichig khereg/2018/ToolA4.doc

00000016

тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг шалгадагч байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулж авах эрхтэй", гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.13, 28.1 дэх заалтуудын дагуу дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн 80 жилийн ойн арга хэмжээний хандивын зарцуулалтын тайлан, тооцоог гаргуулж холбогдох арга хэмжээ авч ажиллан хариу ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

